



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/62/НА-СТА-ТӨҮГ

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэл тайлан	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	8
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	11
4.1 Ерөнхий зүйл.....	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
4.5.1 Завсрын аудитын талаар	12
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Албан шаардлага	13
6. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
МУ	Монгол Улс
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
САЧЭ	Sezione per l'Assicurazione del Credito all'Esportazione
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХХК	Төрийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн, үйлдвэрийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/685

танай _____-ны № _____-т

ТӨВИЙН БҮСИЙН ХҮНС, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
ЦОГЦОЛБОР ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.БЯМБАДОРЖ ТАНАА

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор" ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 211.1 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон 15.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Төрийн банканд 1 жилийн хугацаатай 400.0 сая төгрөгийн хадгаламж байршуулсан, гэрээнд тусгасан байх ёстой доод үлдэгдлээ бууруулсанд 15.6 сая төгрөгийн алданги тооцож нийт хүүгийн орлогоос хасаж тооцуулсан;
- Итали Улсын "IMAGRO" SPA компанитай 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр "Санхүүгийн зөвлөх үйлчилгээ болон мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх худалдан авах" тухай 475.0 мянган еврогийн гэрээ байгуулж, үлдэгдэл 175.0 мянган еврог үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, гэрээ дүгнээгүй, санхүүгийн эх үүсвэргүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан төлөөгүйн улмаас 106.5 сая төгрөгийн хэрэгжээгүй ханшийн алдагдлыг хүлээх эрсдэл үүссэн байна;
- "Эм Эс Эл" ХХК-тай 2022 онд ямааны арьс боловсруулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах гэрээний үлдэгдэл 66.2 сая төгрөг, "Ди Ди Эй Жи" ХХК-ийн химийн агуулахын барилгын зураг төсөв боловсруулах гэрээний үлдэгдэл 64.4

сая төгрөг нийт 130.6 сая төгрөгийг төлөөгүйгээс шүүхийн тогтоолоор 84.0 сая төгрөгийн алданги төлүүлэх шийдвэр гарсны дагуу тайлант онд үйл ажиллагааны бус зардлаар хүлээн зөвшөөрөөгүй, урьдчилж гарсан зардалд бүртгэсэн.

Дээрх зөрчлүүд нь НББОУС болон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.4.1, 6.4.8, 16 дугаа зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй санхүүгийн тайлагналын "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөнтэй холбоотойгоор цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй химийн агуулахын зураг, үхрийн шир, ямаа, хонины арьс боловсруулах үйлдвэрийн барилгын зураг, түүхий эд, агуулахын барилгын зураг зэрэг нийт 1,061.9 сая төгрөгийн өртөг бүхий барилгын зураг эргэлтийн бус хөрөнгөд бүртгэсэн байна.

Дансны өглөгийн 65.6 хувь буюу 729.7 сая төгрөг нь Бүгд Найрамдах Итали улсын Имагро компанитай арьс ширний үйлдвэрийн цогцолборын зураг төсөв боловсруулах, тус улсаас үйлдвэрийн болон цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж авахад САЧЭ-гээс санхүүгийн эх үүсвэр зуучлах 475.0 мянган евро зөвлөх үйлчилгээний төлбөрийн үлдэгдэл 175.0 мянган еврогийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тус компани нь мөнгөн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй, арилжааны банкны хугацаатай хадгаламжид байршуулах хөрөнгийн хэмжээг оновчтой тодорхойлоогүйгээс гэрээний үүргээ бүрэн биелүүлж чадалгүй, хадгаламжийн хүүгийн орлогоо бүрэн хүлээн авах боломжоо алдаж, улмаар хүүгийн алданги тооцуулах эрсдэлийг бий болгосон байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	595,946,940.15	160,610,096.06
1.1.2	Дансны авлага	27,491,900.00	99,742,460.00
1.1.3	Тавар, НДШ авлага	-	648,127.00
1.1.6	Бараа материал	801,785,283.00	762,134,495.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	4,361,558,934.00	2,850,846,679.00
1.1.9	Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	0.00	1,061,951,198.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,786,783,057.15	4,935,933,055.06
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	56,482,412.33	204,256,638.73
1.2.2	Биет бус хөрөнгө	206,108,333.42	203,908,333.46
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	262,590,745.75	408,164,972.19
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,049,373,802.90	5,344,098,027.25
2.1.1.1	Дансны өглөг	1,522,854,562.50	1,111,816,529.00
2.1.1.2	Цалингийн өглөг	-	198,000.00
2.1.1.3	Татварын өр	100.00	-
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,522,854,662.50	1,112,014,529.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,522,854,662.50	1,112,014,529.00
2.3	Эздийн өмч	4,200,000,000.00	4,200,000,000.00
2.3.1	Төрийн өмч	4,200,000,000.00	4,200,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	326,519,140.40	32,083,498.25
2.3.20	Эздийн өмчийн дүн	4,526,519,140.40	4,232,083,498.25
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	6,049,373,802.90	5,344,098,027.25

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого		
5	Хүүгийн орлого	122,975,182.88	29,759,281.55
8	Бусад орлого	1,420,417,326.50	236,024,972.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	647,856,857.10	450,705,717.53
12	Бусад зардал	9,630,219.00	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	40,358,500.00	(106,538,250.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	926,263,933.28	(291,459,713.98)
19	Орлогын татварын зардал		2,975,928.17
20	Татварын дараах ашиг (алдагдал)	926,263,933.28	(294,435,642.15)
27	Тайлант үеийн ашиг, алдагдал нийт дүн	926,263,933.28	(294,435,642.15)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,420,959,240.50	240,921,371.29
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	1,566,533.29
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,420,417,326.50	217,213,568.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	541,914.00	22,141,270.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,077,265,129.24	721,682,829.71
1.2.1	Ажиллагчдад төлсөн	326,692,034.00	248,870,114.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	91,727,469.79	74,724,826.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	9,298,106.00	11,410,200.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	15,195,436.98	4,542,461.46
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	35,421,110.00	29,738,974.01
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,598,930,972.47	352,396,254.24
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(656,305,888.74)	(480,761,458.42)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	154,158,634.93	45,424,614.33
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	154,158,634.93	45,424,614.33
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	154,158,634.93	45,424,614.33
3.1	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(502,147,253.81)	(435,336,844.09)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,098,094,193.96	595,946,940.15
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	595,946,940.15	160,610,096.06

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	4,200,000,000.00	(613,078,126.20)	3,586,921,873.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		13,333,333.32	13,333,333.32
Залруулсан үлдэгдэл	4,200,000,000.00	(599,744,792.88)	3,600,255,207.12
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)		926,263,933.28	926,263,933.28
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	4,200,000,000.00	326,519,140.40	4,526,519,140.40
Залруулсан үлдэгдэл	4,200,000,000.00	326,519,140.40	4,526,519,140.40
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)		(294,435,642.15)	(294,435,642.15)
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	4,200,000,000.00	32,083,498.25	4,232,083,498.25

2.5 Эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэл тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2025 он				Харьцуулалт		
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэтгэл	Хувь
2	Нийт орлого	М.ТӨГ	2,664,809.6	9,538,670.4	5,904,612.3	3,239,802.7	221.6	(3,634,058.1)	61.9
3	Нийт зардал	М.ТӨГ	2,068,862.7	9,532,723.7	5,744,002.2	3,675,139.5	277.6	(3,788,721.5)	60.3
	Үүнээс: Удирдлагын зардал	М.ТӨГ	648,445.4	620,000.3	442,816.2	(205,629.2)	68.3	(177,184.1)	71.4
4	Татварын өмнөх ашиг	М.ТӨГ	-	-	-	-	-	-	-
5	Цэвэр ашиг /алдагдал/	М.ТӨГ	139,225.5	104,701.9	105,439.5	(33,786.0)	75.7	737.6	100.7
6	Төсвийн төлбөрт нийт дүн	М.ТӨГ	12,077.0	-	2,975.9	(9,101.1)	24.6	2,975.9	-
	а/ Орлогын татварт	М.ТӨГ	91,727.4	76,494.6	74,724.8	(17,002.6)	81.5	(1,769.8)	97.7
	в/ НДШ	М.ТӨГ	35,421.1	28,207.3	27,738.8	(7,682.3)	78.3	(468.5)	98.3
8	Нийт ажиллагсдын тоо	ХҮН	9.0	9.0	5.0	(4.0)	55.6	(4.0)	55.6
9	Нийт цалингийн сан	М.ТӨГ	462,648.7	492,968.4	347,933.9	(114,714.8)	75.2	(145,034.5)	70.6
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	М.ТӨГ	2,409.6	2,738.7	2,071.0	(338.6)	85.9	(667.7)	75.6
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	М.ТӨГ	-	-	-	-	-	-	-
12	Хөрөнгө оруулалт	М.ТӨГ	1,420,417.3	8,886,171.3	5,301,185.9	3,880,768.6	373.2	(3,584,985.4)	43.7
13	Нийт авлага	М.ТӨГ	27,491.9	9,868.6	100,192.6	72,898.7	365.2	90,324.0	1,017.3
	Үүнээс: Найдваргүй	М.ТӨГ	-	-	-	-	-	-	-
14	Нийт өглөг	М.ТӨГ	1,522,854.6	984,609.5	1,111,816.5	411,038.1	(73.0)	127,207.0	112.9
	Богино хугацаат өр төлбөр	М.ТӨГ	1,522,854.6	984,609.5	1,111,816.5	411,038.1	(73.0)	127,405.0	112.9
	Урт хугацаат өр төлбөр	М.ТӨГ	-	-	-	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Компанийн шинэчлэгдсэн дүрэмд үндсэн зорилтоо “Дархан арьс ширний цогцолбор төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил, эзэмшил, ашиглалтыг хариуцаж цогцолборт байгаа үйлдвэрлэгчдийг дэд бүтцээр тасралтгүй, найдвартай бүрэн ханган, эдийн засгийн үр ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчийн хөрөнгийг өсгөхөд оршино” гэж тодорхойлжээ.

Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн дүрэмд тус компанийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Дархан арьс ширний цогцолбор төслийн дэд бүтцийг бүтээн байгуулах хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, төслийн ТЭЗҮ-ийн оюуны өмчийг эзэмшигч, хувьцааны ногдол ашгийг холбогдох хуулийн дагуу төвлөрүүлж, хуваарилах;
- Дэд бүтцийг барьж байгуулах, дэд бүтцийн эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах;
- Хөрөнгө төвлөрүүлэх, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх зээл авах, өрийн бичиг (бонд) гаргах болон бусад хэлбэрээр хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгийн баталгаа гаргах;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх, төслийн болон дэд бүтцийн ашиглалтын техник, эдийн засгийн үндэслэл, нөөцийн үнэлгээ, хөрөнгө, санхүүгийн төлөвлөлт хийх.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

МУ-ын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 96 дугаар тогтоолоор “Төвийн бүсийн хүнс хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ТӨХХК дүрмийг шинэчилэн баталсан байна.

“Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ТӨХХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компани нь ХХААХҮЯ-ны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

**Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн 2025
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

“Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайд 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ТӨХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 705.3 сая төгрөгөөр буюу 11.7 хувиар буурсан байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	595.9	160.6	(435.3)
Авлага	27.5	100.4	72.9
Бараа материал	801.8	762.1	(39.7)
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	4,361.6	2,850.8	(1,510.8)
Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		1,062.0	1,062.0
Үндсэн хөрөнгө	56.5	204.3	147.8
Биет бус хөрөнгө	206.1	203.9	(2.2)
Нийт хөрөнгө	6,049.4	5,344.1	(705.3)
Өр төлбөр	1,522.9	1,112.0	(410.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,526.5	4,232.1	(294.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,049.4	5,344.1	(705.3)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 435.3 сая төгрөгөөр буурсан нь Цагаан алт хөтөлбөрөөс 72.5 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 50,000.0 сая төгрөгийн санхүүжилтээс 195.2 сая төгрөг тайланд хугацаанд олгосон нь голлон нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 100.4 сая төгрөг болж, өмнөх оноос 72.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Цагаан алт хөтөлбөрөөс 89.8 сая төгрөгийн санхүүжилтийн авлага нэмэгдэж, байгууллагын авлага 16.9 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 762.1 сая төгрөг болж, өмнөх оноос 39.7 сая төгрөгөөр буурсан нь бичиг хэрэг, хангамжийн материал, шатахууныг 12.8 сая төгрөгөөр худалдан авч, 14.5 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Урьдчилж төлсөн зардал/Тооцоо дансны үлдэгдэл 1,510.8 сая төгрөгөөр өмнөх онооноос буурсан нь Чанарын түншлэл ХХК-тай байгуулсан гэрээний 85.0 хувь буюу 440.4 сая төгрөгийн ажлын гүйцэтгэл цуцлагдсан, компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөнтэй холбоотойгоор цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй арьс ширний үйлдвэр, агуулахын барилгын зураг төсвийг компанийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр 1,062.0 сая төгрөгийг борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 204.3 сая төгрөг болж өмнөх оноос 147.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 157.5 сая төгрөгийн үнэ бүхий түр цахилгаан хангамжийн тоног төхөөрөмжийг худалдан авч, 9.7 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон нь нөлөөлсөн байна.

Дансны өглөг 1,112.0 сая төгрөг болж өмнөх оноос 410.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 4 үйлдвэрийн барилгын зургийн үлдэгдэл төлбөр 195.2 сая төгрөгийг төлж, Чанарын түншлэл ХХК-ийн гэрээний 85.0 хувь буюу 440.4 сая төгрөгийг залруулга бичилтээр бууруулж, Бүгд Найрамдах Итали улсын Имагро компанийн өглөгийн үлдэгдэл 175.0 мянган еврогийн ханшийн тэгшитгэл 106.5 сая төгрөг, шүүхийн шийдвэртэй гэрээт ажлын алданги 86.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

ЗГ-ын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,232.1 сая төгрөг болж өмнөх оноос 294.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд алдагдалтай ажилласантай холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ТӨХХК нь эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 01 дүгээр тогтоолоор “2025 оны эдийн засгийн зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г Засгийн газрын хөрөнгө оруулалтаар 7,144.5 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,514.9 сая төгрөг, хүүгийн орлогоос 45.0 сая төгрөг, бусад 609.6 сая төгрөг, нийт 9,314.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр, хөрөнгө оруулалтын зардалд 8,659.4 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 119.1 сая төгрөг, цалин 493.0 сая төгрөг, өглөг 7.9 сая төгрөг, нийт 9,279.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж баталсан байна.

ТУЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 13 дугаар тогтоолоор “Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд тодотгол хийж, улсын төсвийн хөрөнгө оруулалт 8,886.2 сая төгрөг, захиалагчийн хяналтын зардал 26.6 сая төгрөг, бусад 625.9 сая төгрөг, нийт 9,538.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр, хөрөнгө оруулалтад 8,886.2 сая төгрөг, үйл ажиллагааны зардал 620.0 сая төгрөг, нийт 9,532.7 сая төгрөгийг зарцуулахаар тодотгосон байна.

Гүйцэтгэлээр Засгийн газрын улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт 5,022.3 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 50,000.0 сая төгрөгийн санхүүжилтээс 195.2 сая төгрөг, Цагаан алт хөтөлбөр 22.0 сая төгрөг, нийт 5,239.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, хадгаламжийн хүүгийн орлого 45.4 сая төгрөг, захиалагчийн хяналтын зардал болон бусад 18.3 сая төгрөг, бусад 601.4 сая төгрөг, нийт 5,904.6 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэн үйл ажиллагаа явуулж, хөрөнгө оруулалтын зардалд 5,301.2 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 442.8 сая төгрөг, нийт 5,744.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант хугацаанд нийт зардал 442.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 177.2 сая төгрөг буюу 28.6 хувиар, цалингийн сан төлөвснөөс 145.0 сая төгрөг буюу 29.4 хувиар тус тус буурсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Ашид баланс аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Алтанцэцэг, аудитор Т.Баясгалан, туслах аудитор Б.Доржсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Л.Оюунчимэг, компанийн захирал Л.Майцэцэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Алтанхуяг, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

“Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор” ТӨХХК нь 2025 оны санхүүгийн тайлангаа “Ашид баланс аудит” ХХК-д 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 13 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 1,543.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 15.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой ажлын ачааллыг нягтруулж 4 орон тоо дутуу ажилласнаар цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл зэрэг ажиллагсадтай холбоотой зардал, тогтмол зардлыг 177.2 сая төгрөг буюу 28.6 хувиар хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоож журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар бараа материал, хадгаламжийн данс, хүүгийн орлого, нийт зардлын данстуудад горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулан, асуудлын бүртгэлээр баталгаажуулж, 570.0 сая төгрөгийн 1 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 60.0 сая төгрөгийн 4 албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувь буюу биелсэн гэж үзлээ.

Хүснэгт №2 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	4	60.0	4	60.0	100.0
2	Зөвлөмж	1	-	1	-	100.0
	Нийт дүн	5	60.0	5	60.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг авч үзэхээр боллоо. Үүнд:

1. Дархан арьс ширний боловсруулах үйлдвэр барих ажил зогсонги байдалд орсон, уг үйлдвэр нь 25 га газрыг хамарч баригдахаар төлөвлөгдсөн, төслийн нийт өртөг нь 516,000.0 сая төгрөг, үүнээс 119,000.0 сая төгрөг нь үйлдвэр барих, 397,000.0 сая төгрөг нь барилгын ажил гүйцэтгэх, үйлдвэр ашиглалтад орсон нөхцөлд 2300 орчим ажлын байр шинээр бий болж, жилдээ 4.0 сая богийн арьс, 400.0 мянган бодын арьс боловсруулна гэж тооцсон боловч төслийн зорилгодоо хүрээгүй, чиглэл өөрчлөгдсөнтэй холбоотой зургийн ажил, төсөвтэй холбоотой асуудал;

2. Компанийн нэр, үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж байгаатай холбоотой 2022 онд Дарханы арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК нь Аркосис ХХК, Ричвелл инженеринг ХХК, Гео урбан консалтинг ХХК-уудын түншлэлтэй "Дэд бүтцийн ажлын зураг боловсруулах зөвлөх үйлчилгээ"-ний 892.3 сая төгрөгийн гэрээний хэрэгжилт;

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 211.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 4 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 211.1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 195.7 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Төрийн банканд 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 1 /нэг/ жилийн хугацаатай 400.0 сая төгрөгийн хадгаламж байршуулсан. Гэрээнд тусгасан доод үлдэгдлээ бууруулсан шалтгаанаар 45.4 сая төгрөгийн хүүгийн орлогоос 15.7 сая төгрөгийн торгуулийг суутган тооцуулж, хүүгийн орлогыг бууруулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*”, 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас хүүгийн орлогоо бууруулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Тус цогцолборын гүйцэтгэх захирлын 2025 оны А/03 дугаар тушаалаар БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орны Хөх хот, Ордос хотод үйл ажиллагаа эрхэлж буй хүнсний болон хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн бүтэц тогтолцоо, үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлан Монголын хүнсний болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын боломжийг судлах ажлаар ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, хэвлэлийн төлөөлөгч нарын томилолтын зардалд 4.9 сая төгрөгийг гаргаж, төсвийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Бүгд Найрамдах Итали Улсын “IMAGRO” SPA компанитай 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр “Санхүүгийн зөвлөх үйлчилгээ болон мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх” 475.0 мянган еврогийн үнийн дүн бүхий гэрээ байгуулсан. Гэрээний үлдэгдэл 175.0 мянган евро зөвлөхийн үйлчилгээний төлбөрийг 2021 оноос хойш төлөөгүй, жил бүр ханшийн алдагдлаар төлөх өр төлбөрийн үлдэгдэл нэмэгдэж байна. Тайлант хугацаанд 106.5 сая төгрөгийн хэрэгжээгүй ханшийн алдагдал хүлээсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил,*

гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн зөвлөх үйлчилгээ болон мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх гэрээг дүгнэж, үлдэгдэл төлбөр төлөх эсэх асуудлыг шийдвэрлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. “Эм Эс Эл” ХХК-тай 2022 онд ДААШЦББТӨХХК/202204002 дугаартай багц-2 ямааны арьс боловсруулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах гэрээний үлдэгдэл 66.2 сая төгрөгийг төлөөгүйгээс 43.9 сая төгрөгийн алданги, “Ди Ди Эй Жи” ХХК-тай 2022 онд ДААШЦББТӨХХК/202204002 дугаартай химийн агуулахын барилгын зураг төсөв боловсруулах гэрээний үлдэгдэл 64.4 сая төгрөгийг төлөөгүйгээс 40.1 сая төгрөгийн алданги, нийт 84.0 сая төгрөгийн алдангийг Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-с төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсныг өглөгөөр бүртгэж урьдчилж гарсан зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *“үнэн зөв байх”*, 20 дугаар зүйлийн 20.2.4-т *“нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”*, 20 дугаар зүйлийн 20.2.5-д *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргээ биелүүлээгүй байх, алданги тооцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

6. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		/сая. төгрөгөөр/	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Сахилгын шийтгэл ногдуулах	
						Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төрийн банканд 2025 оны 05 дугаар сарын 09-нд MN830034340601744790 дугаартай 1 жилийн хугацаатай 400.0 сая төгрөгийн хадгаламж байршуулсан. Гэрээнд тусгагдсан доод үлдэгдлээ бууруулсан шалтгаанаар 45.4 сая төгрөгийн хүүгийн орлогоос 15.7 сая төгрөгийн торгуулийг суутган тооцож хүүгийн орлогыг бууруулсан байна.	1	15.7			1	15.7		
2	Тус цогцолборын гүйцэтгэх захирлын 2025.01.17-ны өдрийн А/03 тушаалаар БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орны Хөх хот, Ордос хотод үйл ажиллагаа эрхэлж буй хүнсний болон хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн бүтэц тогтолцоо, үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлан Монголын хүнсний болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын боломжийг судлах ажлаар ХХААХҮЯ-ны Мал аж ахуй бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, хэвлэлийн төлөөлөгч нарын томилолтын зардалд 4.9 сая төгрөгийг гаргаж, төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	4.9			1	4.9		
3	Итали Улсын "IMAGRO" SPA компанитай 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр "Санхүүгийн зөвлөх үйлчилгээ болон мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх" худалдан авах 475.0 мянган еврогийн гэрээ байгуулсан. Гэрээний үлдэгдэл 175.0 мянган евро зөвлөхийн үйлчилгээний төлбөрийг 2021 оноос хойш төлөөгүй, жил бүр ханшийн алдагдлаар төлөх өр төлбөрийн үлдэгдэл нэмэгдэж байна. Тайлант хугацаанд 106.5 сая төгрөгийн хэрэгжээгүй ханшийн алдагдал хүлээх эрсдэлтэй байна.	1	106.5			1	106.5		
4	"Эм Эс Эл" ХХК-тай 2022 онд ДААШЦБТӨХХК/202204002 дугаартай багц-2 ямааны арьс боловсруулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах гэрээний үлдэгдэл 66,2 сая төгрөгийг төлөөгүйгээс 43.8 төгрөгийн алданги, "Ди Ди Эй Жи" ХХК-тай 2022 онд ДААШЦБТӨХХК/202204002 дугаартай химийн агуулахын барилгын зураг төсөв боловсруулах гэрээний үлдэгдэл 64.4 төгрөгийг	1	84.0			1	84.0		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 722/АД150079

Улаанбаатар хот

САГ-2026/62/НА-СТА - ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн банканд 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 1 /нэг/ жилийн хугацаатай 400,000,000.00 /дөрвөн зуун сая/ төгрөгийн хадгаламж байршуулсан. Гэрээнд тусгасан доод үлдэгдлээ бууруулсан шалтгаанаар 45,424,614.33 /дөчин таван сая дөрвөн зуун хорин дөрвөн мянган зургаан зуун арван дөрвөн төгрөг, гучин гурван мөнгө/ төгрөгийн хүүгийн орлогоос 15,665,332.78 /арван таван сая зургаан зуун жаран таван мянга гурван зуун гучин хоёр төгрөг, далан найман мөнгө/ төгрөгийн торгуулийг суутган тооцуулж, хүүгийн орлогыг бууруулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 " үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.5 "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас хүүгийн орлогоо бууруулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Бямбадорж/, Ерөнхий нягтлан бодогч /М.Энхзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

(Handwritten signature)
(Handwritten initials)

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Л.МАЙЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 723/АД/50079

Улаанбаатар хот

САГ - 2026/62/НА - СТА - ТИЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус цогцолборын гүйцэтгэх захирлын 2025 оны А/03 дугаар тушаалаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр монголын өөртөө засах орны Хөх хот, Ордос хотод үйл ажиллагаа эрхэлж буй хүнсний болон хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн бүтэц тогтолцоо, үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлан Монголын хүнсний болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын боломжийг судлах ажлаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, хэвлэлийн төлөөлөгчийн томилолтын зардал 4,937,619.00 (дөрвөн сая есөн гучин долоон мянга зургаан зуун арван есөн) төгрөгийг гаргаж, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.6 "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Бямбадорж/, Ерөнхий нягтлан бодогч /М.Энхзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э. ЭНХБААТАР
Л.МАЙЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 2026/0316 SAG-21.Docx

1526180779



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 721/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/62/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Эм Эс Эл" ХХК-тай 2022 онд ДААШЦББТӨХХК/202204002 дугаартай багц-2 ямааны арьс боловсруулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах гэрээний үлдэгдэл 66,174,044.50 (жаран зургаан сая нэг зуун далан дөрвөн мянган дөчин дөрвөн төгрөг, тавин мөнгө) төгрөгийг төлөөгүйгээс 43,836,978.00 (дөчин гурван сая найман зуун гучин зургаан мянга есөн зуун далан найман) төгрөгийн алданги, "Ди Ди Эй Жи" ХХК-тай 2022 онд ДААШЦББТӨХХК/202204002 дугаартай химийн агуулахын барилгын зураг төсөв боловсруулах гэрээний үлдэгдэл 64,369,525.00 (жаран дөрвөн сая гурван зуун жаран есөн мянга таван зуун хорин таван) төгрөгийг төлөөгүйгээс алданги 40,149,955.00 (дөчин сая нэг зуун дөчин есөн мянга есөн зуун тавин таван) төгрөгийн алданги, нийт 83,956,933.00 (наян гурван сая есөн зуун тавин зургаан мянга есөн зуун гучин гурван) төгрөгийн алдангийг Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-аас төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсныг өглөгөөр бүртгэж урьдчилж гарсан зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.6 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргээ биелүүлээгүй байх, алданги тооцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Бямбадорж/, Ерөнхий нягтлан бодогч /М.Энхзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Л.МАЙЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26 230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-21.Docx

1526180783



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 720/АД150079

Улаанбаатар хот

САГ-2026/62/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүгд Найрамдах Итали Улсын "IMAGRO" SPA компанитай 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр "Санхүүгийн зөвлөх үйлчилгээ болон мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх" 475,000.00 /дөрвөн зуун далан таван мянган/ еврогийн үнийн дүн бүхий гэрээ байгуулсан. Гэрээний үлдэгдэл 175,000.00 /нэг зуун далан мянган/ еврогийн зөвлөхийн үйлчилгээний төлбөрийг 2021 оноос хойш төлөөгүй, жил бүрийн ханшийн алдагдлаар төлөх өр төлбөрийн үлдэгдэл нэмэгдэж байна. Тайлант хугацаанд 106,538,250.00 /нэг зуун зургаан сая таван зуун гучин найман мянган хоёр зуун тавин төгрөгийн хэрэгжээгүй ханшийн алдагдал хүлээсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.6 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх ур нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн зөвлөх үйлчилгээ болон мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэх гэрээг дүгнэж, үлдэгдэл төлбөр төлөх эсэх асуудлыг шийдвэрлэх, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Бямбадорж/, Ерөнхий нягтлан бодогч /М.Энхзаяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Л.МАЙЦЭЦЭГ